



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

додс оны 01 сарын 22 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Г Автомашины тоо төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмал, газрын тосны газрын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Жавхланбаатар, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4. Арга хэмжээний биелэлтийн хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлagnах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн буртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БУРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Н.Нарангэрэл

132000202
2-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2025 оны 01 дугаар сарын 00 өдрийн
34 дугаар тогтоолын хавсралт

АШИГТ МАЛТМАЛ ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДОТООД АЛБАН
АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Үйлчилгээний автомашин	Хөдөө ажлын автомашин (туулах чадвар сайтай)	10
2		Орон нутгийн төлөөлөгчийн газар (туулах чадвар сайтай)	7
3		Хот доторх ажлын суудлын автомашин (жижиг)	2
4		Хөдөө, хот доторх жижиг оврын автобус (микро автобус)	1
	Нийт дүн		20